



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/148/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn
Аудитор: Б.Мөнхболд
Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 01. 30 № 7

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу тус газар нь "Монголын хүүхдийн спортын VII наадам", Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд "Монгол эрийн гурван наадам", "Жангар фестиваль спортын арга хэмжээ", "Эерэг хандлага-Эрүүл нийгэм" аян, аймгийн волейболын холбоотой хамтран Олон улсын волейболын холбооны хөтөлбөрөөр шүүгчийн анхан шатны сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 274,884.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс, биеийн тамирын уралдаан, тэмцээн, багаж техник хэрэгсэл, урсгал засвар зэрэг зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 хөтөлбөр, 5 зорилт, 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 32 арга хэмжээг бүрэн, 4 арга хэмжээг 90.0 хувь буюу нийт дүнгээр 97.92 хувиар биелэлтийг үнэлж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

07020084

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл		/мян.төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	125,285.2	188,052.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	625,528.3	724,044.2
	Нийт хөрөнгийн дүн	750,813.5	912,096.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	325.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	750,813.5	911,770.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	750,813.5	912,096.6
	Үйл ажиллагааны орлогын дүн	548,024.8	1,298,102.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	560,920.9	1,012,750.4
	Үйл ажиллагааны үр дүн	(12,896.2)	285,352.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	20,912.8	50,301.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(33,808.9)	235,050.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	784,622.5	676,720.2
	Тайлант оны үр дүн	(33,808.9)	235,050.5
	Эцсийн үлдэгдэл	750,813.5	911,770.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	508,144.2	881,708.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	508,144.2	881,708.4
	Үйл ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.0	0.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		693,973.0
	Урсгал зардал		693,973.0
	Хөрөнгийн зардал	0.0	0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		697,589.5
	Улсын төсвөөс санхүүжих		697,589.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.0	0.0
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0



Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 153.8 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд эхний үлдэгдлийг 29.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
- Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийг капиталжуулаагүй болон үлдэгдлийг 38.6 сая төгрөгөөр, бараа материалын үлдэгдлийг 3.6 сая төгрөгөөр, нийт 42.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдлийг 44.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайланг 27.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланг 11.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 15.2 сая төгрөгөөр зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15.2 сая төгрөгийн 1 зөрчил² илэрч, зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгсөн.

• Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Биеийн тамир спортын газар	1	29.2			1	29.2	1	29.2				
	1	42.2			1	42.2	1	42.2				
	1	44.1			1	44.1	1	44.1				
	1	27.3			1	27.3	1	27.3				
	1	11.0			1	11.0	1	11.0				
Дүн	5	153.8			5	153.8	5	153.8				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Биеийн тамир спортын газар	1	15.2	-	-	1	15.2	-	-				
Дүн	1	15.2	-	-	1	15.2	-	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			